

АЛТАН АРСАМЖ

VOL.3

1/2000

“РУСЬ” БҮЮУ “ОРОС” ХЭМЭЭХ НЭРИЙН ТАЙЛЛАГА

МУИС, ОУХС-ийн багш

д/д. Д.Энхбат

Эрт үеэс бодгаль хүн хүрээлэн буй байгаль дэлхий хийгээд юм үзэгдлийн мөн чанараа танин мэдэхийг оролдон улмаар уул ус оршин буй газар орноо өөрт буй хамгийн ойр дөт хэмжүүр болох өөрийн бие эрхтэн, тэдгээрийн хэсэг, гадаад хэлбэр зэрэгтэй адилтган зүйрлэж эш болгон нэрийдэн хэрэглэж байсны улбаа нь газар орны, ус нэр, хүний нэр, овог омог, ард түмний нэрэнд шингэн үлдсэн байдаг. Жишээ нь газар орны, уул ус зэргийг хүн өөрийн эрхтнүүдээр нэрлэдэг байсан нь нийт ард түмэнд түгээмэл байсан бөгөөд монгол хэлнээ “уулын ам, хоолой”, “хамар даваа”, “зүрх уул”, “уушиг уул” зэргээр эш болгон хэрэглэсэн нь бий. Мөн үүний сацуу эртний овог аймгууд хава нийлэн нүүдэллэх бусад овог угсаатны талаар хомс мэдлэгтэй, бас тухайн овог аймгуудтай зарим тохиолдолд газар нутаг булаалдан тэмцэлдэж улмаар дайждаг байсан зэргээс үүдэн өөрсдөө нэр өгөх тохиолдол байсан аж. Жишээ нь эртний гөрөгүүд харь угсаатан нүүдэлчдийг “варвар” буюу буйтнагчид хэмээн нэрлэсэн нь тэдний хэлийг мэдэхгүй хэл нэвтрэлцэхгүй байсантай холбоотой агаад хожим нь европ дахинаа “бүдүүлэг” гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ.

Монгол төрхт үндэстэн эрт дээр цагаас инагш өөрсдийгөө амьтнаас ялгаатай оюун ухаант “Хүмүүн” хэмээн нэрлэж ирсэн бөгөөд хожим нь хүн төрөлхтөний их нүүдлийн улбаагаар дэлхий дахинаа цацагдсан монголжуу төрхөт үндэстнүүд болох монгол, сумбэ, скиф, хионит, ги ди байдди, ихэс (иго), индиан зэрэг олон зуун үндэстэн өөрсдийгөө “инуит” буюу “бид хүмүүс” хэмээн

нэрийдсэн байдаг. Монголчууд хятадуудыг Нанхиад хэмээн нэрлэсэн байдаг нь “нан”-дотор “хин” буюу дотор хүн хэмээн нэрлэсэн нь өдгөө хүртэл улбаалагдан үлджээ.

МЭӨ VII зууны үед Хар далайн хойд биеэр нутаглаж байсан эртний Скифүүд зугтан Азиар дамжин Илийн хөндий, Дөлгөөн мөрний сав газар, Чуйн хөндий, Балгаш, Тагна уулаар тархан амьдрах Нохой жүн, Уулын жүн нартай нүүдэллэн холилдох болсон нь Жунгийн зургаан аймгийн дотроос Ихэс (Игэ), Нохос (Цюань), Хүн (Кунь) нартай ураг барилдсан мэдээ байдаг хийгээд Скиф аймгийн дотроос Миргит, Хирад Халкис, Сак аймгууд хүчирхэгжин гарч ирснийг түүхчид тэмдэглэдэг билээ. Энэхүү аймгуудын дотроос Цагаан ди (Байдди) Урал хүртэл нүүдэллэн нутаглаж Чиди буюу Улаан Ди нар зүүн зүг их нүүдлийн аянд гарч өдгөөгийн Камчат, Чукотыг дамжин улмаар Аляск хүрсэн нь Индиан буюу улаан хүмүүс хэмээн нэрлэгдэх болсныг түүх гэрчилнэ. Диан гэдэг нь хүн (нү) хэлний, “хиан” буюу хүн гэсэн үгийн язгуур хэмээн тайлдаг бөгөөд овог монгол хэлний үг бөгөөд гарвал зүйн хувьд Скиф Жунди нар холигдох явцад уг хэлэнд үлдсэн Чонос гэсэн эртний овог аймгийн нэр билээ). Иймээс уг үг нь латин хэлэнд “чанес-чанис” эртний ир хэлэнд “Чо(гон)”, Гот хэлэнд “Кундс”(Кинто), Литов хэлэнд “Чуо(сунс)”, тохар хэлэнд “ку”, семит хэлэнд “-киан”, урал хэлнээ “кийон”, тунгус(хамниган) хэлэнд “хена” – зэргээр буюу “чоно”, “нохой” гэсэн утгаар уламжлагдан үлдсэн байдаг.

МЭӨ 57-55 онд Хүн нар ар, өвөр болон салсан үеэс ар Хүн нарын ихэнх хэсэг нь Дундад Азиар дамжин, Каспийн тэнгис Дунайн саваар нутаглан улмаар Вавилонны түүхэнд Хионит буюу Цагаан Хүн нар хэмээн нэрлэгдэн үлджээ. Эдгээр Цагаан хүн нар МЭ 522 онд Хятад руу довтолж улмаар энэтхэг хүрсэн агаад Энэтхэгчүүд “ХУНА” хэмээн тэмдэглэжээ. Судлаач Лха.Дарьсүрэн агсан нострат буюу “бидний хэл” хэмээх судалгаандаа Монгол хэмээх үгийн эртний хэлбэрийг “Мон-гу-ал” буюу “Бид улаан хүн” хэмээн тайлсан байдаг.

Аливаа угсаатан, овог аймаг үндэстэний нэр өөр өөрийн үүх түүхтэй байдаг. Ямарваа нэгэн угсаатны нэрийн үүсэл нь

1. Өөрийн нэр (тухайн үндэстэн өөрөө өөрсдийгөө нэрлэсэн)
2. Бусдын өгсөн нэр (бусад үндэстэн бусад угсаатнаас

ялгарах шинжээр нь нэрлэсэн нэр) Эдгээр нэрийн аль аль нь сурвалж бичигт үлдсэн байдаг. Лувсанданзангийн "Алтан товч"-д ...Замбултивийн ертөнц хэмээнэ. Түүнд есөн өнгийн улс бүлгээ. Есөн өнгө улс нь: Энэтхэг улс цагаан өнгөтэй буюу. Түвдийн улс хар өнгөт буюу. Гууль улс хөх өнгөт буюу. Нохой улс хүрэн өнгөт буюу. Эрээн улс ганц хөлт улс буюу. Монгол улс дөрвөн өнгөт улс буюу" зэргээр хөрш зэргэлдээ орших улсуудаа нэрлэсэн байдаг хийгээд эдүгээ ч зарим нэр нь сурвалж бичигт тэмдэглэгдэн хэрэглэгдэж байна. Жишээ нь Энэтхэг улсыг Жагарын орон (буюу Цагаан Хятад) Хятад улсыг Жанаг (Хар Хятад) хэмээн нэрлэдэг нь бий. Энэ утгаар орос үндэстний нэрийн талаарх өөрийн таамаглал, саналаа цухас дурдсу.

Сурвалж бичигт орос үндэстэн Висла мөрний эх Тиса мөрөн, Карпатын уул хавь буюу өдгөөгийн Унгар (Мажар), Өмнөд Польш хавиар нутаглаж байсан мэдээ бий. МЭ I зууны үед Герман овгуудтай хаая нийлэн славян овгийнхон нутаглаж байсан гэж үздэг. МЭ VI зуунд амьдарч байсан Византийн түүхч Кесарийн Прокопий "Дорныг Өрний нүдээр харах нь" бүтээлд "Эдгээр слав, ант овгийнхон аянга цахилгааныг буй болгогч бурхан бүхний эзэн хэмээн шүтэн үхэр алж өргөл барьдаг.

«... Зарим нь огт хувцасгүй, цамц хүрэм өмсдөггүй зөвхөн өргөн эдээр бэлхүүсээ халхалсан... гадна байдлаараа хоорондоо төсөөтэй, маш өндөр, асар хүч чадалтай» хэмээн бичиж тэмдэглэдэг.

Византийн император Маврикий "тэд (славян, ант-нар) ... маш олуул, тэсвэртэй, халуун хүйтэн, бороо, хувцас хунаргүй, өлмөн зөлмөн байх зэрэгт маш тэсвэртэй ... гэж дурдсан байдаг.

МЭ-ний VI-VIII-зууны үед зарим слав үндэстнийг ч нутгийн хойд хэсэгт "Венед" хэмээн нэрлэдэг байсан нь өдгөө ч эстони хэлэнд хадгалагдан үлджээ. Харин өмнө зүгт "Склавин", баруун зүгт "ант" буюу "Поляне" гэж нэрлэдэг байсан аж.

Орос хэмээх нэрийн талаар олон тайлбар таамаглал байдаг хийгээд судлаач Д.А.Мачинский "Орос" гэдэг үг нь "роса" буюу "шүүдэр" хэмээх үгээс гаралтай хэмээн тайлбарласан нь нилээд мадагтай юм. Олон эрдэмтэд үг нэр нь "rouls", "rois" буюу өвөг герман хэлний "droit" буюу дайчид гэсэн үгээс үүссэн хэмээн тайлбарладаг бол Р.А.Агеева "Страны и народы": происхождение

названий" номондоо "Русь" гэдэг үг нь "rosomany" буюу "русь", "шар уст хүмүүс" гэдэг үгээс үүсэлтэй хэмээн тайлбарласан байдаг.

МЭ I зууны үед хионит буюу Цагаан хүн нар Европт нүүдэллэн очиж улмаар тархан суурьшсан үед тэд нар (хүн(нү) нар) соёл, аж байдал, хэрэглээ, ухамсарын төвшний хувьд суурин байсан ард түмнээс хамаагүй илүү хөгжилтэй байсан хийгээд торго даавуу хэрэглэж хувцас хунар оёж өмсдөг, алт, мөнгө, хүрэл, төмөр зэргээр эд зүйлс, эдлэл хэрэглэл, гоёлын зүйлс, зэр зэвсэг хийн ашигладаг нүүдэлчдийн нилээд боловсронгуй соёл иргэншилтэй ард түмний хувьд Европ буюу "наран жаргах" зүгт нүүдэллэн очихуй тэр цагт тухайн газар нутгийн оршин суугчид нийгмийн хөгжил, соёл, аж байдлын хувьд хөгжлийн нилээд доод төвшинд буюу нүүдэлчдийг бодвол арай хоцрогдонгүй, ан агнуур эрхлэн, тэдгээрийн арьсийг боловсруулан хувцас оёж өмсдөг байснаас үүдэн "арьстан" хэмээн өмссөн хувцасаар нь нэрлэснээс "арьс", "орос", "Рось", "Русь" хэмээх нэр үүссэн гэж бид таамаглаж байна. Үг нэр нь эдүгээ англи хэлэнд "rass", герман хэлэнд "rasse", орос хэлэнд "раса", франц хэлэнд "расе" зэргээр олон хэлэнд "арьс" гэсэн утгаар одоо ч хэрэглэгдсээр байгаа аж. Үүнээс үзэхүл орос үндэстэн бусад үндэстэн нэрлэсэн нэр нь бусад хэлний аман яриа, сурвалж бичигт хэрэглэгдсээр хожим нь хадгалагдан үлдсэн бөгөөд харин орос үндэстэн өөрсдийгөө нэрлэсэн нэр нь мартагдсан гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Нэг үндэстэн нөгөө үндэстэнээ нэрлэсэн ийм жишээ дэлхийн улс үндэстэн бүрд түгээмэл байдгийн дээр судлан үзэхүл тэр үеийн хүмүүсийн сэтгэлгээний онцлог, нэрлэх арга, нэр өгөх ёсон болон бусад ястан үндэстнийг болон өөрсдийгөө хэрхэн нэрлэж байсан талаар чухал баримт болох нь дамжиггүй юм.